

**ХӨДӨӨ АЖ АХУЙН МАРКЕТИНГ ТӨСЛИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
/2016 оны жилийн эцсийн байдлаар/**

2016 оны 03 сарын 30-ны өдөр

№	Хөтөлбөр/төслийн агуулга		Гүйцэтгэл					
1	Төслийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Хөдөө аж ахуйн маркетинг төсөл P125964, Даян дэлхийн хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал хөтөлбөрийн буцалтгүй тусламжийн гэрээ, TF014820, 2013 оны 7 сарын 3)		Хөдөө аж ахуйн маркетинг төсөл нь Мал аж ахуйд суурилсан үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулах, зэх зээлтэй холбох, нэр төрлийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулах замаар хөдөөгийн хүн амын амьжиргааг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилготой. Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгийн 15 суманд хэрэгждэг.					
2	Санхүүжилтийн эх үүсвэр		Даян дэлхийн хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал хөтөлбөр-Дэлхийн банк (Нийт төсөв 11.0 сая ам доллар)					
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа		Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын хөгжлийн ассоциаци					
			Төсвийн ерөнхийлөн захирагч: ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга					
			Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ, УЦУОШГ, ГХГЗЗГ, ХААИС, МААЭШХ, Аймаг, сумдын ЗДТГ, аймгийн ХХААГ					
			Хэрэгжих хугацаа: 2014.02.05-2017.01.31 Хэрэгжих хугацааг 2017.12.31. хүртэл сунгасан.					
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		1. Малчдыг зах зээлтэй холбох 2. Малын ашиг шим чанарыг сайжруулах 3. Төслийн удирдлага					
5	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)	Нийт төсөв 11,000,000 ам.доллар					
		Үүнээс:	2014-2016 онд	2016 онд	2016 оны төсвийн нийт төсөвт эзлэх хувь			
		Бүрэлдэхүүн хэсэг 1	2,593,581.5	1,692,569.3	35.4			
		Бүрэлдэхүүн хэсэг 2	3,971,111.9	2,393,166.6	54.7			
		Бүрэлдэхүүн хэсэг 3	1,325,479.8	517,022.7	28.0			
		<b>Нийт</b>	<b>7,890,173.2</b>	<b>4,602,758.6</b>	<b>41.8</b>			
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ					
	1-р зорилтын хүрээнд:		Үнэлгээний тайлангийн 4-5 дугаар хуудаснаас харна уу.					
	2-р зорилтын хүрээнд:		Үнэлгээний тайлангийн 5-8 дугаар хуудаснаас харна уу.					
	3-р зорилтын хүрээнд:		Үнэлгээний тайлангийн 8-10 дугаар хуудаснаас харна уу.					
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)		Дэмжлэг авах хүсэлтэй этгээд төслөөс сонгон шалгаруулсан мэргэжлийн зөвлөгөө өгөх багийн удирдлага дор дэд төслийн саналаа хамтран боловсруулдаг. Нэмүү өртгийн сүлжээний 12, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний 67, малын эрүүл мэндийн 67, малын үржлийн 41, малын тэжээл, тэжээллэгийн 18, нийт 205 дэд төслийг санхүүжүүлж, хөрөнгө оруулалт хийсэн байна.					
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		ХХААХҮЯ болон аймгийн ХХААГ, сумдын мал эмнэлэг, үржлийн тасагтай хамтран хэрэгжүүлэх ажлын уялдаа, хамтын ажиллагаа хангалттай сайн байв.					
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ) Төсөл хэрэгжиж эхэлснээс хойших үнэлгээгээр	Биелэлт дундаж	Зорилты н тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт3		
		86.7%	3	70.0%	100%	95.0%		
		Төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 62.8 %, төслийн үйл ажиллагааны гүйцэтгэл 86.4 % буюу “хангалттай” үнэлгээтэй байна.						
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)		Нэгдсэн үнэлгээ					
			..... %					

**“ХӨДӨӨ АЖ АХУЙН МАРКЕТИНГ” ТӨСЛИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
/2016 оны жилийн эцсийн байдлаар/**

2016 оны 03 сарын 30-ны өдөр

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Үнэлгээний зорилго нь арга хэмжээний гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан тогтоож, тэдгээрийн хоорондын зөрүүг илрүүлэн дүн шинжилгээ хийж шалтгааныг тодруулах, түүнд үндэслэн зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

**ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ**

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу 2016 оны жилийн эцсийн тайланг судлах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, холбогдох газруудаас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

**ГУРАВ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

**Төслийн хамрах хүрээ:** Говь-Алтай, Завхан, Архангай, Баянхонгор, Хөвсгөл аймгийн 15 суманд хэрэгжиж байгаа.



**Төслийн зорилго**

Мал аж ахуйд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тогтолцооны ашиг шимийг сайжруулах, зах зээлтэй холбох, нэр төрлийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулах замаар хөдөөгийн хүн амын амьжиргааг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг хангахад оршино.

**Төслийн зорилт**

**БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ-1. МАЛЧДЫГ ЗАХ ЗЭЭЛТЭЙ ХОЛБОХ**

**1.1. Мах, ноос, ноолуурын зах зээлийг хөгжүүлэх:**

- 1.1.1. Нэмүү өртөг шингэсэн мах, ноос, ноолуурын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн түншлэлийн талаар малчид, малчдын бүлэг, хоршооны гишүүдийг мэдээллээр хангах, чадавхижуулах;
- 1.1.2. Сүү цуглуулах, боловсруулах, зах зээлд гаргах чиглэлээр мэдээллээр хангах, чадавхижуулах;
- 1.1.3. Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах, арчлах, борлуулах чиглэлээр мэдээллээр хангах, чадавхижуулах;

1.1.4. Бизнес төлөвлөгөө боловсруулах, экстейшний үйлчилгээний чиглэлээр техникийн туслалцаа үзүүлэх, хөрөнгө оруулалт хийх;

**1.2. Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийг хөгжүүлэх:**

1.1.5. Малчдын жижиг бүлгүүдэд бүтээгдэхүүнээ сүүний үйлдвэрт эсхүл орон нутгийн хэрэглэгчдэд нийлүүлж, зах зээлтэй болоход нь туслах зорилгоор экстейшний үйлчилгээ үзүүлж, бизнес төлөвлөгөө боловсруулах зэрэг техникийн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах;

1.1.6. Малчдын жижиг бүлгүүдэд сүү цуглуулах туршилтын загвар болон бага оврын сүүний үйлдвэрт хөрөнгө оруулах зорилгоор оролцоот санхүүжилт олгох;

**1.3. Хүнсний ногоо, жимс, жимсгэний туршилтын үйлдвэрлэл:**

1.3.1. Орлого багатай өрх толгойлсон эмэгтэйчүүд, ажилгүй иргэд, цөөн малтай малчдад өрхийн хоол хүнсний нэр төрөл, орлогын эх үүсвэрийг олшруулахад боломж олгох зорилгоор хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэл болон боловсруулалтад хөрөнгө оруулах замаар бичил санхүүжилт олгох;

1.3.2. Хүнсний ногоо, жимс, жимсгэний жижиг үйлдвэрлэгчдэд бүтээмжийг нь нэмэгдүүлэх зорилгоор экстейшний үйлчилгээ үзүүлэх болон бизнес, төлөвлөгөө боловсруулахад техникийн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах;

## **БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ-2. МАЛЫН АШИГ ШИМ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ**

**2.1. Малын эрүүл мэндийг сайжруулах: Малын өвчингүй эрүүл бүсийг бэхжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх замаар малын ашиг шим, эрүүл мэндийг сайжруулна.**

2.1.1. Мал эмнэлгийн тоног төхөөрөмж, хангамжийн материал хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүйтэн хэлхээ, лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах;

2.1.2. Малын эрүүл мэндийн хяналтын цэг, хамгаалалтын бүсийн шалгах цэгийг байгуулах зэргээр шүлхий, бруцеллез өвчинд хяналт тавих хөтөлбөр хэрэгжүүлэх;

2.1.3. Мал эмнэлгийн анхан шатны нэгжийг бэхжүүлэх, сүргийн эрүүл мэндийн менежментийн үйлчилгээ үзүүлэх;

2.1.4. Малын эмч болон мал эмнэлгийн бусад мэргэжилтнүүдэд зориулсан сургалт зохион байгуулах;

**2.2. Малын үржил, сонгон үржүүлэг: Хонь, ямаа, сүүний болон махны чиглэлийн үхэрт хөрөнгө оруулах замаар малын чанар, малын үржлийн ажлын менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.**

2.2.1. Малын үржлийн үйлчилгээний нэгж байгуулах эсхүл засварлан сайжруулах, багаж хэрэгслээр хангах;

2.2.2. Сумын мал аж ахуйн мэргэжилтэн, зохиомол хээлтүүлгийн техникч, малчид, сүүний чиглэлийн фермерүүдийг сургалтад хамруулах;

2.2.3. Удам зүйн хувьд сайжирсан малын нөөц бүрдүүлэхийн тулд цөм сүрэг бий болгох;

2.2.4. Багаж тоног хэрэгслээр хангах замаар сумын түвшинд зохиомол хээлтүүлэг хийх чадавхийг сайжруулах;

2.2.5. Гарваль ашиг шимээр баталгаажсан малыг малчдад борлуулах зорилгоор нийлүүлэх;

**2.3. Малын тэжээл, тэжээллэг: Малын тэжээллэгийг сайжруулах замаар малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.**

2.3.1. Малын тэжээл үйлдвэрлэл, малын тэжээл боловсруулах, тэжээх хөтөлбөр хэрэгжүүлэхэд нь малчдын бүлэгт хөрөнгө оруулалт хийх зорилгоор оролцоот санхүүжилт олгох;

2.3.2. Малын тэжээллэг, ашиг шим, ашигт ажиллагааны хоорондын уялдааг нийт үйлдвэрлэгчдэд сайтар ойлгуулах зорилгоор оролцоот хээрийн судалгааг зохион байгуулах;

## **БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ-3. ТӨСЛИЙН УДИРДЛАГА**

**3.1. Төслийн хэрэгжилт, зохицуулалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор техникийн туслалцаа үзүүлэх сургалт зохион байгуулах.**

**Төслийн нийт төсөв:**

“Даян дэлхийн хөдөө аж ахуй, “Хүнсний аюулгүй байдал хөтөлбөр”-ийн хүрээнд Дэлхийн банкны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр нийт 11.0 сая ам долларыг төсөвлөсөн.

**Төсөл хэрэгжих хугацаа:** Буцалтгүй тусламжийн гэрээнд уг төслийг 2014 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхээр заасан ба хэрэгжиж дуусах хугацааг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан.

## ДӨРӨВ. ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### Төсвийн зарцуулалт

Зардлын ангилал	Нийт төсөв, ам.доллар	2014-2016 онд зарцуулсан төсөв, ам.доллар	2016 онд зарцуулсан төсөв, ам.доллар	Төсвийн үлдэгдэл	
				ам.доллар	Хувь
Малчдыг зах зээлтэй холбох	4,776,861.8	2,593,581.5	1,692,569.3	2,183,280.3	45.7
Малын ашиг шим, чанарыг сайжруулах	4,378,714.8	3,971,111.9	2,393,166.6	407,602.9	9.3
Төслийн удирдлага	1,844,423.4	1,325,479.8	517,022.7	518,943.6	28.1
ДҮН	11,000,000	7,890,173.2	4,602,758.6	3,109,826.8	28.3

## ТАВ. ТӨСЛИЙН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

### БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ-1. МАЛЧДЫГ ЗАХ ЗЭЭЛТЭЙ ХОЛБОХ:

#### 1.1. Мах, ноос, ноолуурын зах зээлийг хөгжүүлэх

Дэд төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх багийн нийт зөвлөхийг мах, сүүний чиглэлээр дэд төсөл боловсруулахад онцгойлон анхаарах хүчин зүйл, үйлдвэрлэлийн техник, технологи, Монгол Улсад мөрдөж буй хууль тогтоомж, стандартын сургалтад хамруулж зохих мэдлэг олгосон байна.

Дэлгэрэнгүй жагсаалтад 72 дэд төслийн санал багтсан ба Дэлхийн банк, ХХААХҮЯ-аас тавьсан шалгуурыг хангаж буй 8 дэд төслийн ашиг хүртэгчидтэй Дэд төсөл хэрэгжүүлэх гурван талт болон Санхүүжилтийн гэрээ байгуулж холбогдох санхүүжилтийг олгож эхэлсэн. Үүнд махны салбарын 6, ноос ноолуурын салбарын 2, дэд төсөл багтаж байна. Мөн Говь-Алтай аймагт байгуулагдсан анхны мах боловсруулах үйлдвэрт 300.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсний дүнд үйлдвэрийн өргөтгөл барилга, хөргүүрийн өрөө, гүн хөлдөөх өрөө, 288 тонн-ы хадгалах зоорь, бүтээгдэхүүн тээвэрлэх машин зэргийг худалдан авч үйл ажиллагаа явуулахад бэлэн болжээ.

#### 1.2. Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийг хөгжүүлэх

Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэж хэрэгжүүлэх зөвшөөрөл авсан байх, дэд төслийг хэрэгжүүлэхэд 10%-аас доошгүй хувь оролцоог өөрийн дансанд бэлэн төвлөрүүлсэн байх, санхүү, эдийн засаг, зах зээлийн шалгууруудыг бүрэн хангасан байх, нэмүү өртгийн сүлжээг стратегийн түншлэлийн түвшинд хөгжүүлэхэд ач холбогдолтой оролцох зэрэг шалгуурыг хангасан сүүний салбарын 2, малын тэжээл, маркетингийн 2 дэд төслийг шалгаруулан санхүүжилт олгож эхэлсэн. Нэмүү өртгийн сүлжээ хөгжүүлэх нийт 12 дэд төсөлд 2.5 тэрбум төгрөг олгосон байна.

#### 1.3 Хүнсний ногоо, жимс, жимсгэний туршилтын үйлдвэрлэл

Эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний ногоо, жимс жимсгэнээр хөдөөгийн иргэдийг хангах эрхэм зорилгын хүрээнд 67 төсөл шалгаруулж 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн байна. Төслийн санхүүжилтээр бага оврын 36 трактор, түүний туслах хэрэгслэл, 85 хүлэмж, 10 орчим нэр төрлийн боловсруулах техник, тоног төхөөрөмж, 18 усалгааны систем, усалгааны дагалдах хэрэгслүүд, 13 зоорь, 5 худаг, хашаа, гар багаж хэрэгсэл үр, үрсэлгээ зэргийг худалдан авсан байна. Түүнчлэн хүнсний ногоо хадгалалт, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Газрын Алим” компани санхүүгийн дэмжлэг авч Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд 300 тонны багтаамжтай хүнсний ногоо, нарийн ногоо, жимс жимсгэнэ хадгалах агуулах барьж 2016 оны 11 сард ашиглалтанд оруулжээ.

Төслийн үйл ажиллагааны үр дүнд төслийн оролцогч сумдад хүнсний ногоо, жимс жимсгэний аж ахуй эрхлэх нөхцөл бодитоор сайжран ургацын хэмжээ өмнөх жилүүдийнхээс 3.5 дахин нэмэгдсэн, зарим сумдад хүнсний ногооны хэрэгцээний 30.0 гаруй хувийг, төмсний хэрэгцээг бүхэлд нь хангадаг болсон, хүнсний ногооны хэрэглээний нэр төрөл нэмэгдсэн, ажлын байр

нэмэгдсэн, бага орлоготой малчдын өрхийн орлого өссөн, сумдад хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалт хийж өрхийн орлого нэмэгдсэн, бут, сөөг, модлог ургамалын үржүүлэг хийдэг болсон, төслөөс санхүүжилт авсан хоршоодын дотоод хяналт, санхүү, тайлан бүртгэл хөтлөлт нь сайжран, өөрсдийн бизнес төлөвлөгөөтэй болж орлогын хувиарлалтыг тодорхой хяналттай явуулж эхэлсэн байна.

#### **Дадал хэвшил бий болгох үйл ажиллагааг дэмжсэн экстейншиний материал**

Хүнсний 10 төрлийн ногоо тухайлбал төмс, шар лууван, шар манжин, хүрэн манжин, бөөрөнхий байцаа, бөөрөнхий сонгино, төл сонгино, хэрэглээний сонгино, сармис, тарвас, амтат гуаны агротехнологийн зөвлөмжийг төслийн аймгуудын газарзүйн онцлог байдалд тохируулан шинэчлэн сайжруулсан гарын авлага боловсруулж 3000 ширхэг хэвлүүлэн төслийн ашиг хшртэгчид хүргэж мөн сургалтын авлага байдлаар ашиглаж байна.

Төмс, хүнсний ногоо зоорилох арга ажиллагаа, арчилгаа, технологийн горим, 3 төрлийн зоорь барих техникийн нөхцөл, барилгын зураг, ашиглалтын горим мөн өвлийн болон нийлэг хальсан хүлэмж, нийлэг хальсан бүхээг, хаалттай шилэн дарлага хийх арга ажиллагаа, хийлэг хальсан хүлэмжинд хэмх, улаан лооль, чинжүү ургуулах арга ажиллагааны талаархи зөвлөмжийг багтаасан гарын авлага боловсруулж 3000 ширхэг хэвлүүлэн төслийн ашиг хүртэгчид хүргэсэн.

Чацаргана, алим,үхэр нүд, гүзээлзгэнэ, интоор зэрэг 5 төрлийн жимс жимсгэнэ тарих, арчлах, ургуулах арга ажиллагааны зөвлөмжийг багтаасан гарын авлага боловсруулж 3000 ширхэг хэвлүүлэн төслийн ашиг хүртэгчид хүргэж мөн сургалтын авлага байдлаар ашиглаж байна.

### **БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ-2. МАЛЫН АШИГ ШИМ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ**

#### **2.1. Малын эрүүл мэндийг сайжруулах: Малын өвчингүй эрүүл бүсийг бэхжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх замаар малын ашиг шим, эрүүл мэндийг сайжруулна.**

Төсөл хэрэгжиж буй Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн хэлтэс, лаборатори, эдгээр аймгийн 15 сум, бүсийн мал эмнэлэг хорио цээр, хяналтын 4 цэгт малын эрүүл мэндийн чиглэлээр нийт 67 дэд төсөл хэрэгжүүлж байна.

#### **Сумдын хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд**

Мал эмнэлгийн үйлчилгээний зөөврийн хашаа, автомат шприц, туулга олгогч, мал угаалгын шүршигч аппарат, ус зөөх том сав, зөөврийн цахилгаан үүсгүүр, мал эмнэлгийн анхан шатны бүртгэл, мэдээ, тайлан, сургалт, нэвтрүүлэх үйлчилгээ зэргийн хэрэгцээнд зориулж зөөврийн болон суурин компьютер, олон үйлдэлт хэвлэгч, лабораторийн оношлогоо, шинжилгээнд зориулж микроскоп, мах, сүү шинжлэгч багаж, малын паразиттах өвчнийг эмчлэх, сэргийлэх эм худалдан авч хөрөнгө оруулалтыг хийсэн. Үүний үр дүнд халдварт өвчний вакцинжуулалт, паразиттах өвчний угаалга, туулгалт, боловсруулалтын арга хэмжээний чанар, ажлын бүтээмж сайжирч, цаг хугацаа хэмнэх, ажиллах хүч, хөдөлмөр хөнгөвчлөх зэрэг олон давуу талууд бий болжээ.

#### **Сумдын мал эмнэлэг, үржлийн тасагт**

МЭҮТ-ийн албан ажлын хэрэгцээ, сургалт, семинар, нэвтрүүлэх үйлчилгээ, мэдээлэл, сурталчилгаа зэрэг ажилд зориулж зөөврийн болон суурин компьютер, олон үйлдэлт хэвлэгч, проектор, дэлгэц, тог баригч, зургийн аппарат, яаралтай дуудлага, шуурхай үйлчилгээнд зориулж 15 мотоцикл, байршил тогтоогч худалдан авч хөрөнгө оруулалт хийсний зэрэгцээ мал эмнэлгийн вакцины их багтаамжийн 40 хөргүүр, лабораторийн 10 хөргөгч, хөлдөөгч, вакцины тээвэрлэлт, хадгалалтын үеийн температурыг бүртгэгч 20 багаж, бэлэн байдлын зөөврийн 20 цахилгаан үүсгүүрийг тус тус нийлүүлсэн байна.

#### **Аймгийн мал эмнэлгийн хэлтэс, лабораторид**

Аймгуудын мал эмнэлгийн хэлтэс, лабораториудад нийтдээ 28 нэрийн 58 ширхэг багаж, тоног төхөөрөмж нийлүүлснээс гадна вакцин тээвэрлэх хөргүүртэй машиныг төслийн оролцогч 5 аймгийн Мал эмнэлгийн хэлтэст хүлээлэгэн өгчээ. Эдгээр аймгууд төслийн хөрөнгө оруулалтаар вакцин тээвэрлэх хөргүүртэй машинтай болж байгаагийн зэрэгцээ төслийн оролцогч 15 сумын Мал эмнэлэг үржлийн тасагт вакцин хадгалах хөргүүр нийлүүлсэн нь малын вакциныг үйлдвэрлэлээс хэрэглэгч хүртэл стандартын дагуу хүйтэн, сэрүүн хэлхээгээр тээвэрлэн чанар, баталгаат байдлыг хадгалж, хэрэглэх нөхцлийг бүрдүүлж, хүйтэн хэлхээний цогц тогтолцооны загварыг бий болгосон байна.

**Бүсийн мал эмнэлэг хорио цээр, хяналтын цэгт**

Бүсийн мал эмнэлэг хорио цээр, хяналтын цэгийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, тус ажлын үр дүнд тулгуурлан шаардлагатай хөрөнгө оруулалт хийж чадавхжуулсан. Энэ хүрээнд 22 нэрийн 75 ширхэг багаж, тоног төхөөрөмж нийлүүлсний үр дүнд Монгол орны баруун, төв, зүүн бүсийн хооронд мал, амьтны шилжилт хөдөлгөөн, малын гаралтай бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдалд байнгын хяналт тавих орчин нөхцлийг бүрдүүлж, сүүлийн үед гаралт, дэгдэлттэй байгаа шүлхий, цэцэг, бог малын мялзан зэрэг өвчнийг хянах, эрүүл болон хамгаалалтын бүсийн найдвартай байдлыг хангахад чухал ахиц дэвшил гарсан байна.

**Дадал хэвшил бий болгох үйл ажиллагааг дэмжсэн экстейншиний материал**

Малын эрүүл мэндийн чиглэлээр анхан шатны мэдлэг олгох 8 хэвлэлийн хуудас бүхий малчдад зориулсан “Бэлчээрийн монгол малд түгээмэл тохиолддог өвчин” гарын авлагыг боловсруулан 2,000 ширхэг хэвлүүлж, ашиг хүртэгч нарт тараасан. Энэ гарын авлагыг малчдид хүлээн авснаар малын халдварт, халдваргүй мөн празиттах гэсэн 3 төрлийн өвчний шинж тэмдэг, түүнээс урьдчилан сэргийлэх, өвчилсөн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл авч өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх дадал хэвшил бий болгоход дэмжлэг үзүүлэх юм.

Малын галзуу, шүлхий, бруцеллез өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий 3 төрлийн нугалбарыг боловсруулан төслөөс зохион байгуулсан Малын эрүүл мэндийн анхан шатны сургалтад оролцогчид болон төслийн Оролцогч аймаг сумдын малчдад хүргүүлсэн.

Сум, аймгийн мал эмнэлгийн нэгж, байгууллага, малын эмч нарт зориулан дараах 3 төрлийн төлөвлөгөөт ажлын ханын хуанли боловсруулсан, Малын халдварт мялзан төст өвчин болон шүлхий, цэцэг өвчний гарах шалтгаан, оношлогоо, урьдчилан сэргийлэх, тэмцэх, арга замын талаар тус бүр 10 минутын 3 багц нэвтрүүлэг бэлтгэж “Малчин” суваг ТВ-ээр нэвтрүүлсэн.

Мал, амьтны халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалт, Тандалт шинжилгээ, паразиттах өвчний арга хэмжээ, МЭАЦЭА-н арга хэмжээ, Малын халдваргүй өвчин, эндемик өвчин, ордлого гэсэн үндсэн 3 төрлийн ажил, үйлчилгээг ханын плакат байдлаар боловсруулж хэвлүүлэн мал эмнэлгийн нэгж, байгууллагуудад хүргэн ажлын хэрэгцээнд нь ашиглуулж байна. Ингэснээр орон нутагт мал эмнэлгийн ажил, үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах, хянах үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулах юм.

**2.2. Малын үржил, сонгон үржүүлэг: Хонь, ямаа, сүүний болон махны чиглэлийн үхэрт хөрөнгө оруулах замаар малын чанар, малын үржлийн ажлын менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ**

Малын үржил, сонгон үржүүлгийн чиглэлээр оролцогч 5 аймгийн 30 суманд 41 дэд төсөл хэрэгжүүлж байгаагаас 20 дэд төслийн хүрээнд бог малын хээлтүүлэгчийг аж ахуйн нэгжид төвлөрүүлэн мэргэжлийн байгууллага, мэргэжилтний хяналтад авч, малын чанар сайжруулахад эрчимтэй ашиглах, 19 дэд төсөл нь цөм сүрэг бүрдүүлэх замаар өсвөр хээлтэгч, хээлтүүлэгчийг чиглэлтэй өсгөн бойжуулж бусад мал бүхий иргэн, хуулийн этгээдийг хангах, 2 дэд төсөл нь гардан ба зохиомол хээлтүүлгийн аргаар мах, сүүний хосолмол өндөр ашиг шимт Монбельярд үүлдрийн үхэр, сүүний Альпино үүлдрийн ямааг цэврээр үржүүлж хэрэгцээний эрлийзжүүлэгт ашиглах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Төслийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн ажлын үр дүнд хуцны 65.7, ухнын 65.2% тус тус цөм сүргийн жишигт тэнцэж, өмнөх оныхоос 9.7-8.5 пунктээр ахисан, нийт эм хонины 25.3%, эм ямааны 22.1% жишигт тэнцэж 2015 оныхтой харьцуулахад 3.5-2.7 хувиар нэмэгдсэн, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн үржлийн мал энэ онд том мал, төлийн хамт бүгд 5937 тоо толгойд хүрч 18.8%-иар өссөн, сүүлийн хоёр жилд гарсан төлөөс өсвөр 3351 толгой хуц, 1887 толгой ухна шинээр шилэн сонгож, өсгөн бойжуулснаар хээлтүүлэгч сүрэг сэлбэгдсэн, мөн орон нутагт 3,739 толгой хээлтэгч бүхий 19 цөм сүрэг, 2,896 толгой хээлтүүлэгч бүхий 20 хээлтүүлэгч сүрэг бүрдэж өвс, тэжээл, хашаа хороогоор хангагдсанаар мал үржлийн ажил, үйлчилгээний мэргэжлийн байгууллага, мэргэжилтний хяналтын дор өсвөр хээлтүүлэгчийг чиглэлтэй өсгөн бойжуулах, хээлтүүлэгчийг хээлтүүлгийн бус улиралд ялган төвлөрүүлэх, технологийн дагуу арчилан маллах, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулах, үржлийн шаардлага хангасан сайн чанарын хээлтүүлэгчийг малчдад гэрээ, түрээсээр ашиглуулдаг үйлчилгээний зохистой хэлбэр бий болж, мал үржлийн ажлыг мэргэжлийн түвшинд удирдан явуулах нөхцөл бүрдсэн байна.

**Дадал хэвшил бий болгох үйл ажиллагааг дэмжсэн экстейншиний материал**

Монгол Улсад одоо мөрдөж байгаа бог малын тарга хүч тодорхойлох уламжлалт болон гадаадын судлаачдын боловсруулсан нийтлэг аргуудыг харьцуулан судлах үндсэн дээр бог малын тарга хүч

тодорхойлох хялбаршуулсан гарын авлагыг “Хөдөө аж ахуйн дэвшилтэт технологи нэвтрүүлэх институт”-тэй хамтран боловсруулж 10,000 ширхэг хэвлэн, төслийн Оролцогч сумдын ашиг хүртэгч нарт тараасан. Энэ аргачлалыг мэдэж авснаар малын ашиг шимийг зөв тодорхойлон малын үүлдэр угсааг сайжруулах, мал сүргийн үүлдэрлэг байдлыг бий болгох боломж бүрдсэн байна.

Малын ашиг шим чанарыг дээшлүүлэх төслийн хөгжлийн зорилтын хүрээнд гойд ашиг шимтэй малыг олон нийтэд таницуулах, өсгөн үржүүлэх чадавхи бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор Мал эмнэлэг үржлийн газартай хамтран ашиг шим өндөртэй Шилмэл 5 хошуу мал, малын ашиг шимийг тооцох хэмжилт хийх арга бүхий зурагт танилцуулга бэлтгэн 300 ширхэг хэвлэн ашиг хүртэгч нарт хүргүүлж эхэлсэн.

### **2.3.Малын тэжээл, тэжээллэг: Малын тэжээллэгийг сайжруулах замаар малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.**

Малын тэжээл, тэжээллэгийн чиглэлээр 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 18 дэд төсөл хэрэгжиж байгаа ба том оврын 16 трактор, 15 анжис, 15 хадуур, 15 хаман боогч, 31 үрлэгч зэрэг малын тэжээлийн ургамал тарих, боловсруулахад шаардлагатай бусад тоног төхөөрөмж, дагалдах багаж хэрэгсэл, 4-5 төрлийн нэг болон олон наст тэжээлийн ургамлын үр зэргийг худалдан авсан байна.

Төслөөс санхүүжилт авч малын ногоон тэжээл тариалж буй 18 хоршоо, аж ахуйн нэгж нь гэрчилгээ бүхий 2,394 га газар эзэмшиж байгаа бөгөөд 1,856.4 га газар хашаалан, 2016 онд 1,382 га газарт тариалалт хийж, 2,158.7 тн ногоон тэжээл бэлтгэж, 710 тн байгалийн хадлан авч, 180.8 тн үр тариа хураан авсан байна. Үүний үр дүнд алслагдсан бүсүүдэд малын тэжээл бэлтгэлийн тогтолцоо бий болж сумдын малын тэжээлийн болон тэжээлийн агуулахын хангамж сайжирсан байна.

### **Дадал хэвшил бий болгох үйл ажиллагааг дэмжсэн экстейншиний материал**

Нэг болон олон наст тэжээлийн ургамал тарихад баримтлах зарчим, сорт сонгох, үрийг тариалалтад бэлтгэх, тарих хугацаа тохируулах, үрийн норм, тарих арга, бордоо, усалгаа, арчилгааны талаархи зөвлөмжийг багтаасан гарын авлагыг боловсруулж 4,000 ширхэг хэвлүүлэн Оролцогч аймаг сумуудын ашиг хүртэгчидэд тараасан.

Тэжээлийн хэрэгцээг тооцох арга, тэжээлийн түүхий эдийн нөөцийг нэмэгдүүлэх арга, Бүдүүн тэжээл (өвс), Багсармал холимог тэжээл, Эрдэс нэмэгдэл тэжээл, Шүүст тэжээл (Дарш), Ердийн найрлагат багсармал холимог тэжээл бэлтгэх арга,ажиллагааны зөвлөмжийг багтаасан гарын авлага боловсруулж 4,000 ширхэг хэвлүүлэн Оролцогч аймаг сумуудын ашиг хүртэгчидэд тараан малын тэжээлийн бэлтгэх зөвлөмжөөр хангасан.

Өвөл хаврын улиралд мал тэжээх, бордох арга ажиллагаа тухайлбал мал сүргийг нэмэгдэл тэжээлээр тэжээх, үхэр хонь болон төлд зориулсан тэжээл бэлтгэх технологи, тэжээх арга, мал бордох арга ажиллагаа бүхий гарын авлагыг доктор С.Тогтохбаяр боловсруулж, 3,000 ширхэг хэвлэн малчдад хүргэсэн.

Дэд төслийн ашиг хүртэгч нарт зориулсан малын ногоон тэжээл, 11 төрлийн хүнсний ногоо, жимс жимсгэний технологийн карт боловсруулж тараах ажлын төлөвлөгөөний дагуу зөвлөх агрономич С.Жаргалсайхантай гэрээ байгуулан гүйцэтгүүлж 300 ширхэг хэвлүүлэн ашиг хүртэгч нарт хүргүүлсэн.

Нэг ба олон наст тэжээлийн ургамал тарих агротехнологийн зөвлөмж бүхий зайны сургалтад зориулсан 47 минутын видео хос цомгийн эхийг доктор С.Жигжидсүрэнтэй хамтран бэлтгэж, төслийн цахим хуудаст байрлуулсан байна.

Нэг болон олон наст наст тэжээлийн ургамал мөн байгалийн түүхий эд ашиглан малын 5 төрлийн тэжээл тухайлбал Малын тэжээл бэлтгэх хэрэгцээ шаардлага, малын тэжээлийн нэгжийг тодорхойлох арга ажиллагаа, Малын шүүст тэжээл, дарш, Малын бүдүүн тэжээл /өвс/, Малын эрдэс тэжээл, Ердийн найрлагат багсармал холимог тэжээл бэлтгэх талаар талбайн болон танхимын сургалт хосолсон ний 75 минут бүхий 5 видео хичээлийг доктор С.Дүгэрсүрэнтэй хамтран бэлтгэж төслийн цахим хуудаст байрлуулсан.

## **БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ-3. ТӨСЛИЙН УДИРДЛАГА:**

### **Төслийн удирдах хороо**

Төслийн удирдах хороо 2016 онд 2 дугаар сарын 9-нд хуралдаж нэмүү өртгийн сүлжээний 72 дэд төсөл, төслийн 2015 оны үйл ажиллагааны тайлан, 2016 оны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан байна.

**Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх баг**

Төслийн хэрэгжилтийг хянах, төслийн шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг шалгах, төслийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээг хийх, тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Дэлхийн банкны Хөдөө аж ахуйн маркетинг төсөл хариуцсан багийн ахлагч Стефан Форманаар ахлуулсан баг 4 удаа ажиллахдаа 2017 оны хэрэгжилтэд анхаарах асуудлаар зөвлөмж өгснөөс гадна төслийн үйл ажиллагаанд “Хангалттай сайн” гэсэн үнэлгээ өгсөн байна.

**Удирдлагын мэдээллийн систем**

Төслийн бүх шатны мэдээлэл, ашиг хүртэгчдийн бүртгэлийг хийх зорилгоор Удирдлагын мэдээллийг бий болгож бүрэн ашиглалтанд орууллаа. Уг системийг ашиглалт оруулснаар Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний баг болон төсөлд хамрагдах хүсэлтэй иргэд уг системээр дамжуулж дэд төслийн саналаа хүргүүлэх боломжтой болсон. Түүнчлэн Хөдөө аж ахуйн маркетинг төсөл нь ашиг хүртэгчдийн тоог давхардуулахгүй байх үүднээс регистрийн дугаар бүртгэх бүртгэлийн системийг нэвтрүүлсэн. Төслийн тайлан, шалгуур үзүүлэлтийн биелэлтэнд шаардлагатай бүхий л мэдээллийн сан Удирдлын мэдээллийн системд бүрдүүлсэн байна.

**Мэдээлэл сурталчилгааны чиглэлээр**

Төслийн Олон нийттэй харилцах, мэдээлэл сурталчилгааны стратеги төлөвлөгөөнд заасны дагуу мэдээлэл сурталчилгааны кампанит ажлыг жил бүрийн төлөвлөгөөний дагуу үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулжээ. Ингэснээр төслийн санхүүжилтээр дэд төсөл хэрэгжүүлж буй ашиг хүртэгч нар мэдээлэл, мэдлэг олж авч дадал хэвшил болгосоноор төслийн хөрөнгө оруулалтыг үр дүнтэй ашиглах, цаашид үйл ажиллагаагаа тогтвортой эрхлэх эхлэл тавигдсан байна. Төслийн ашиг хүртэгч, хэрэгжүүлэгч, хандивлагч нарт төслийн хэрэгжилтийн талаар мэдээлэл тогтмол хүргэснээр төслийн хэрэгжилтийг ил тод нээлттэй болгох, сайн туршлагыг олон нийтэд хүргэх боломжийг бүрдүүлжээ. Төсөл 140 минутын ТВ-ын нэвтрүүлэг, 114 минутын радиогийн нэвтрүүлэг, 125 минутын видео хичээл бэлтгэн үндэсний болон орон нутгийн телевизээр нэвтрүүлсний зэрэгцээ, төслийн цахим хуудаст байрлуулсан байна.

Орон нутгийн хувьд, төслийн оролцогч аймаг, сумд бүрт хэрэгжиж буй төслийн хэрэгжилт, үр дүн, явцыг тухайн орон нутгийн иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор Баянхонгор, Хөвсгөл, Говь-Алтай, рхангай аймгуудын орон нутгийн телевиз, радио, сонинд мэдээ, сурвалжлагууд тогтмол нийтлүүлжээ. Монгол орны өндөр уулын нөхцөлд тохирох тэжээлийн ургамал сонгох туршилт, судалгааны ажил, талбайн үзүүлэх сургалтыг 2015 оны 5-8 дугаар саруудад үе шаттайгаар Баянхонгор аймгийн Галуут суманд зохион байгуулах үеэр ТВ-ийн цуврал 2 удаагийн сурвалжлага бэлтгэн тус аймгийн ТВ-ээр нэвтрүүлсэн байна.

Мөн оролцогч аймаг сумуудын ашиг хүртэгч малчдын бүлэг, хоршоо компани аж ахуйн нэгжүүдийг дэд төсөл бичих техник, эдийн засгийн үндэслэл тодорхойлох арга зүйгээр хангах зорилгоор 3 цуврал бүхий “Хөдөөгийн хөрөнгө оруулалт” гарын авлагыг 300 ширхэг хэвлүүлэн ашиг хүртэгч нарт хүргэсэн байна. Үүний зэрэгцээгээр төслийн улирлын сонин болон төслийн цахим хуудсыг тогтмол шинэчилэн төслийн санхүүжилт авах ашиг хүртэгч нарт шаардлагатай мэдээллийг шуурхай хүргэж байна. Тухайлбал, төслийн Улирлын сонинг 4 дугаар бэлтгэн хэвлэж 15 сумын 8000 өрхөд тараасан байна.

**Худалдан авах ажиллагаа**

Төслийн буцалтгүй тусламжийн гэрээний дагуу төслийн нийт худалдан авах, санхүүгийн үйл ажиллагаанд Дэлхийн банкны журам, дүрмийн мөрдлөг болгон ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлэх нэгж (ГХН) нь Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 18 сараас доошгүй хугацаагаар бэлтгэн Төслийн буцалтгүй тусламжийн гэрээнд зөвшөөрөгдсөн бараа, ажил, үйлчилгээний гэрээнүүд, гүйцэтгэгч/нийлүүлэгчийг сонгох шалгаруулах аргачлалууд, төсөв, төлөвлөгөөт хугацаа болон Банкнаас тавих хяналт зэргийг тусган Дэлхийн банкаар хянуулж батлуулдаг. 2016 оны төслийн худалдан авалтын төлөвлөгөөг 2015 оны 12 дугаар сарын 15-нд батлуулсан бөгөөд тус төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаа нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон байна.

Олон улсын болон Дотоодын нээлттэй тендерээр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа жилд нэг удаа Хэрэгжүүлэгч байгууллага Тендерийн үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилдог бөгөөд 2016 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн А-18 тушаалаар ХХААЯ-ны СБТГ-ын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Б.Цогбадрахаар ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй Тендерийн үнэлгээний хороо худалдан авалтыг зохион байгуулсан байна.



Малын эрүүл мэнд, үржлийн чиглэлээр хөрөнгө оруулалт авсан төслүүдийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтууд болон Төслийг олон нийтэд таниулах, сурталчлах ажлын худалдан авалтыг төсөл хэрэгжүүлэх нэгж зохион байгуулж байна.

2016 онд Олон улсын нээлттэй тендер шалгаруулалтын аргачлалыг ашиглаагүй бөгөөд Дотоодын нээлттэй тендер шалгаруулалтаар нийт 5 гэрээ, орон нутгийн оролцоот шалгаруулалтаар 27, харьцуулалтын аргаар 23 гэрээний сонгон шалгаруулалтыг гүйцэтгэжээ.

### **Санхүүгийн хяналт, шалгалт**

2015 оны Санхүүгийн тайлан, санхүүгийн бичиг баримтад Дэлхийн банкнаас томилсон аудит (Конфиденс аудит)-ын шалгалт орсон байна. Аудитаар төслийн санхүүгийн тайлан, НББ-ийн анхан шатны бичиг баримтууд, худалдан авалтын бичиг баримтууд, холбогдох бусад бүх бичиг баримтуудыг НББ-ийн олон улсын стандарт, Буцалтгүй тусламжийн гэрээний заалтуудыг удирдлага болгон шалгажээ. Аудитын үр дүнд Санхүүгийн тайлангууд НББ-ийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн, Төслийн санхүүжилтийг зөвхөн төслийн зориулалтаар зарцуулсан, Буцалтгүй тусламжийн заалтыг дагаж мөрдсөн байна, ямар нэгэн зөрчилгүй, гэсэн дүгнэлт гарчээ.

Дэлхийн банкнаас 2 удаа шалгалт ирж 2016 оны санхүүгийн үйл ажиллагааг шалгасан байна. Санхүүгийн бүх баримтуудыг түүвэрлэн шалгахад ямар нэгэн материаллаг зөрчил гараагүй байна. Санхүүгийн үйл ажиллагаа Дэлхийн банкаар батлагдсан Санхүүгийн үйл ажиллагааны гарын авлага болон Сангийн сайдын баталсан Буцалтгүй тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журмын дагуу явагдаж байна гэсэн дүгнэлт гаргажээ.

## **ЗУРГАА: ҮНЭЛГЭЭ**

### **6.1. Төслийн дотоод мониторинг**

Төслийн хэрэгжилтийг хянах болон техникийн туслалцаа үзүүлэх зорилготойгоор Төсөл хэрэгжүүлэх нэгжийн мэргэжилтнүүд төслийн оролцогч 15 суманд ажилласан. Мөн түүнчлэн төслийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Мал эмнэлэг, үржлийн тасаг (МЭҮТ)-тай хяналт шинжилгээ, үнэлгээний гэрээ байгуулсан. Ингэснээр сумын түвшинд гарч буй асуудлыг богино хугацаанд тодорхойлох, шийдвэрлэх, мэдээлэл солилцох боломжтой болж байна.

Гэрээнд заасны дагуу 2016 оны Өрхийн судалгааг МЭҮТ сумын түвшинд зохион байгуулан нийт 1,000 өрхөөс судалгаа авсан. Судалгаанд оролцогчыг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч ТХН-ийн бэлтгэсэн асуулгаар судалгаа авч байна. Судалгааны асуулга нь шалгуур үзүүлэлт нь шалгуур үзүүлэлтийн биелэлт, сургалт, малын эрүүл мэнд, малын тэжээл, тэжээллэг болон олон нийттэй харилцах гэсэн эсгүүдээс бүрддэг.

Төслийн дунд шатны үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээний уулзалт, семинар, сургалт, зөвлөгөөнд оролцогчдын тоог заасан байдаг. Үүний дагуу ТХН энэ шалгуур үзүүлэлтэд чиглэсэн хоёр удаагийн сургалт зохион байгуулж 411 хүн хамруулав. 2016 оны 11 дүгээр сарын 1-9-ны өдрүүдэд 3 аймгийн Оролцогч бүх сумдын Мал эмнэлэг, үржлийн тасаг болон хувийн хэвшлийн мал эмнэлгийн нэгжийн удирдлагуудад төслийн үйл ажиллагааны мониторинг, хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулах талаар сургалт зохион байгуулж 109 хүн хамрууллаа. Энэ үеэр төслийн бүрэлдэхүүн хэсгүүд тухайлбал малын эрүүл мэнд, малын үржил, малын тэжээлийн дэд бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр төслийн хэрэгжилтийн явцын мониторингийг хэрхэн хийх, төслийн хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр МЭҮТ-ийн дарга нарт чиглэл, зөвлөгөө өглөө.

Түүнчлэн 2016 оны 11 дүгээр сарын 6-23-ны өдрүүдэд Оролцогч бүх сумдад зохион байгуулсан хоршооны удирдлага, санхүү бүртгэл хөтлөлтийн чадавхийг сайжруулах, бизнес төлөвлөгөөтэй болгох сургалтын үеэр гишүүдийн оролцоотой хоршооны хөгжил, чадавхийн хяналт, үнэлгээ хийх сургалтыг зохион байгуулж 302 хүн хамрууллаа. Сургалтад оролцсон гишүүд хоршооны үйл ажиллагааг гишүүдээр нь үнэлүүлэх, хянуулах ажлыг гүйцэтгэх тохиромжтой арга зүйтэй болсон нь гишүүдийг идэвхижүүлэх, улмаар хоршооны тогтвортой хөгжлийг хангахад чухал боллоо.

### **Төслийн нөлөөллийн үнэлгээ**

Дэлхийн банк нь төслийн үр нөлөө, үр дүнг үнэлэх зорилготойгоор дунд хугацааны бие даасан хөндлөнгийн нөлөөллийн үнэлгээний судалгааг төслийн Оролцогч аймаг, сум, хяналтын сумдад хийх ажлыг гүйцэтгэх олон улсын тендер зарласан. Судалгааны гол зорилго нь орон нутгийн түвшинд төслийн хэрэгжилт хэрхэн амжилттай хэрэгжиж, шалгуур үзүүлэлтэнд хүрсэн эсэх болон төслийн гол зорилтот бүлгүүдэд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох зорилготой юм. Судалгаанд төслийн оролцогч 15 сум болон хяналтын 15 сум хамрагдаж байна. Тендерг Монгол Улсаас

оролцсон “Эс Ай Си Эй” компани шалгарч судалгааны мэдээлэл цуглуулах ажил эхлэхэд бэлэн болоод байна.

Байгаль орчинд нөлөлөх байдлын үнэлгээ

Хөдөө аж ахуйн маркетинг төслийн хүрээнд дэд төслүүдийг хэрэгжүүлэх үйл явцад байгаль орчинд сөрөг нөлөөгүй, зохистой техник, технологийг эхнээс авч хэрэгжүүлэхэд туслах зорилгоор дагаж мөрдөх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Дэлхийн банк боловсруулсан. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн баримт бичгийн салшгүй хэсэг бөгөөд төслийг хэрэгжүүлэх хүрээнд гарч болзошгүй байгаль орчны аливаа бохирдол, эрсдлээс урьдчилан сэргийлэх, байгаль орчны талаар анхаарах асуудлуудыг дэмжих зорилготой юм. Энэ төлөвлөгөөнд Монгол Улсад төслийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх шаардлагатай аюулгүйн зааварчлагуудыг тусгасан бөгөөд Дэлхийн банкны Үйл ажиллагааны бодлого 4.01-ыг даган биелүүлэхтэй холбоотой зааварчлагуудыг төслийг дэмжигч, хэрэгжүүлэгч, ашиг хүртэгч талуудад зөвлөмж болгодог бөгөөд төсөлд хамрагдагч талууд энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан шаардлагуудыг өөр өөрсдийн хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёстой бөгөөд төслийн Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний баг, ашиг хүртэгч болон бусад оролцогч талуудын төлөөллийг энэ чиглэлээр сургах шаардлагатай гэж заасан байдаг.

Түүнчлэн Хөдөө аж ахуйн маркетинг төслийн дунд шатны үнэлгээгээр эдгээр хүмүүст Байгаль орчны менежментийг төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлийн чадавхижуулах үйл ажиллагаа зохион байгуулахыг зөвлөсөн. Тиймээс төслийн Оролцогч аймгуудын МЗҮБ-ийн орон нутгийн зөвлөхүүдэд зориулан “Дэд төслийн санал боловсруулахад байгаль орчны нөлөөллийг тооцох, байгаль орчны менежментийн төлөвлөлт хийх нь” сэдэвт сургалтыг 2016 оны 6 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд, аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн, төслийн Оролцогч сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт зориулан “Байгаль орчны менежментийг төлөвлөгөө ба түүний хэрэгжилтэд хяналт тавих арга зүй” сэдэвт сургалтыг 2016 оны 9 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан байна.

Төслийн үйл ажиллагааны болон санхүүгийн үнэлгээ

Дэлхийн банкны төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх баг төслийн 2016 оны үйл ажиллагааг “Хангалттай сайн” гэж үнэлсэн бол Дэлхийн банкны санхүү, худалдан авалтын хяналт шалгалтын үр дүнгээр төслийн худалдан авах ажиллагаа “Сайн”, санхүүгийн ажиллагаа “Хангалттай сайн” гэсэн үнэлгээгээр дүгнэгдсэн байна.

### 6.2. Төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт

№	Төслийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд	Суурь үзүүлэлт	3 дахь жилийн зорилт	2016 оны гүйцэтгэл	(%)
<b>Төслийн зорилгод түвшиний үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд</b>					
1	Төслийн бодит болон зорилтот ашиг хүртэгчдийн тоо, хүйсээр ангилсан	0 гэж тооцно	8110	13334	100
2	Мал аж ахуйн болон сонгогдсон тохиолдолд хүнсний ногооны гаралтай өрхийн орлогын өсөлт	Жилд МАА-аас 3847374 төгрөг, Хүнсний ногоо, жимс жимсгэнээс 16717 төгрөгийн орлого олсон.	15%	Дурдсан орлого өмнөх оныхоос нэмэгдсэн хэдий ч мөнгөн дүнгээр илэрхийлсэн судалгаа байхгүй	50.0
3	Гэрээний үндсэн дээр дамжуулан борлуулж байгаа бүтээгдэхүүний хувь хэмжээ	Шаардлага хангах суурь судалгаа хийгдээгүй учраас ТХН суурь судалгааг дахин хийнэ.	80%	Судалгаа хийгдээгүй үр дүнг, тайлагнаагүй.	0
4	Мал аж ахуйн бүтээгдэхүүний (мах, сүү, ноос, ноолуур) өсөлтийн хувь	Нэг өрхийн жилийн мал аж ахуйн бүтээгдэхүүний хэмжээ (Суурь судалгаа) Мах-499,66 кг Сүү-1,996.02 л Ноос-142.74 кг Ноолуур- 31.34кг	10%	Нэмүү өртгийн сүлжээ хөгжүүлэх 12 дэд төсөлд 2.15 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.	30.0
5	Нэг хүнд ногдох төрөл бүрийн хоол хүнсний	DIME байгууллагын хийсэн судалгааны ажил	3%	Төмс, хүнсний ногооны хангамж өмнөх оноос	50

	орцын өөрчлөлт, хүйс болон эмзэг бүлгээр ангилсан	нь амьжиргааны доод түвшингийн орлоготой өрх болон хүйсээр ангилаагүй учир дахин хийх шаардлагатай		11.9 хувиар нэмэгдэж, хэрэгцээнийхээ 38.7 хувийг хангадаг болсон, хэрэглэж байгаа жимсний нэр төрөл нэмэгдсэн.	
<b>Дундаж</b>					<b>46.0</b>
<b>Дунд хугацааны шалгуур үзүүлэлтүүд</b>					
1	Үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэлийн түншлэлийн тоо	0 гэж тооцно	10	Мах боловмруулах үйлдвэр-1, Хүнсний ногоо боловсруулах-1,	20.0
2	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэлийн дараах менежмент (нэмүү өртгийн сүлжээ)-ийг сайжруулсны үр дүнд гарсан үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт	0 гэж тооцно	10%	Судалгаа хийгдээгүй үр дүнг, тайлагнаагүй.	0
3	Зах зээлд холбогдсон малчдын хоршооны тоо	0 гэж тооцно	10	Хоршоодын нийт тоо 64 байгаа ба ашиг хүртэгч нарт зориулсан 2 үе шаттай сургалтад 302 оролцогч хамрагдсан.	100
4	Хүнсний ногоо, жимс, жимсгэний сургалтад хамрагдсан болон үйлдвэрлэл эрхэлж буй эмэгтэйчүүдийн тоо	10 гэж тооцно	40	Ашиг хүртэгч 787 өрхийн 3978 хүн, үүнээс 1144 эрэгтэй, 1270 эмэгтэй 1564 хүүхэд байна.	100
5	Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх сайжруулсан арга ажиллагаа нэвтрүүлсэн малчдын тоо (ДЦХААХАБХ-ийн шалгуур үзүүлэлт), хүйсээр ангилсан	0 гэж тооцно	7000	Малын ногоон тэжээл тариалж буй 18 хоршооны шууд ашиг хүртэгч нь 1325 өрхийн 4182 хүн (эр 1226, эм 1287) байна.	40.0
6	Хамтарсан судалгааны тоо	0 гэж тооцно	4	Нийт 5 хамтарсан судалгаа хийж гүйцэтгэв.	100
7	Тэжээлтэй холбоотой малын ашиг шимийн өсөлт:	Доорх дэд шалгуур үзүүлэлтүүдээр гаргана.	=	Доорх дэд шалгуур үзүүлэлт-тээр гаргана.	=
7-1	Төллөлтийн хувийн өсөлт	0	2%	Судалгаа хийгдээгүй	0
7-2	Төрөх үеийн жингийн өсөлт	0	3кг	Хурганы төрөх, ялгах, ялгасны дараах үеийн жинг хяналтын бүлэгтэй харьцуулахад 0.5-6.3 кг илүү жинтэй байв.	50.0
7-3	Амьдын жингийн өсөлт	0	3%		50.0
7-4	Малын гулуузны жингийн нэмэгдэл	0	3кг	Судалгаа хийгдээгүй	0
8	Малын эрүүл мэнд – өвчний хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх чадавхи сайжирсан	Доорх дэд шалгуур үзүүлэлтүүдээр гаргана.	=	Доорх дэд шалгуур үзүүлэлт-тээр гаргана.	=
8-1	Тэжээлийн үйлдвэрлэл эрхлэх газрыг ашиглаж эсхүл өмчилж буй зорилтот бүлгийн тоо (өрх толгойлсон эмэгтэйчүүдээр ангилсан)	0 гэж тооцно	45	Ногоон тэжээл тариалж байгаа 18 хоршоо, ААН газар эзэмших гэрчилгээтэй.	40.0

8-2	Сургалт, мэдлэг олгох арга хэмжээнд оролцож буй малчдын тоо (хүйсээр ангилсан)	0 гэж тооцно	7000	Нийт 81 удаагийн сургалтад давхардсан тоогоор 6975 оролцогч хамрагдсан.	80.0
8-3	Малын дотно, гадна паразит өвчний эрүүл мэндийн байнгын хяналтын дадал хэвшилтэй болсон малчдын тоо (хүйсээр ангилсан)	Суурь судалгаа хийх шаардлагатай	7000	Малын эрүүл мэндийн сургалтад 1113 малчин хамрагдсан, 2000 ширхэг гарын авлагыг малчин өрхүүдэд тараасан.	70.0
8-4	Вакцин болон дээж тээвэрлэх хүйтэн хэлхээ, стандарт үйл ажиллагааны журам байгаа эсэх, түүнийг ашиглах буй эсэх	0 гэж тооцно	3	Оролцогч 5 аймаг, 15 суманд сэрүүн хэлхээний иж бүрэн машин, тоног төхөөрөмж нийлүүлсэн	100
9	Генетик ба үржил – бий болгосон цөм сүргийн тоо	0 гэж тооцно	5	3739 толгой эх мал бүхий 19 цөм сүрэг бүрдээд байна.	100
10	Цөм сүргээс нийлүүлсэн хээлтүүлэгчийн тоо	0 гэж тооцно	1000	2849 толгой хуц, ухна, 45 бух, 2 буур нийт 2896 хээлтүүлэгч нийлүүлэгдсэн.	100
11	Сургалтад хамрагдсан Зохиомол хээлтүүлгийн техникчийн тоо	0 гэж тооцно	90	2014-2015 онд 70 хүн 2016 онд 20 хүн бэлтгэгдсэн	100
12	Тэжээл, тэжээллэг – сумын түвшинд тэжээлд зориулсан газрын хэмжээ, га	0 гэж тооцно	1500	Ногоон тэжээл тариалдаг хоршоо, ААН нийт 2394 га газар эзэмшдэг.	100
13	Тэжээл, тэжээллэг – тэжээлийн удирдлага, мал тэжээх талаар сургалтад хамрагдсан малчдын тоо	0 гэж тооцно	6000	2015 онд 895 малчин, 2016 онд 1680 оролцогч сургалтад хамрагдсан.	40.0
<b>Дундаж</b>					<b>62.6</b>
<b>Удирдлага, тайлангийн чанар</b>					
14	Үр ашигтай, үр дүнтэй төслийн удирдлага	-	Хангалттай сайн	Хангалттай	80.0
15	Төслийн хэрэгжилтийн тайлангийн чанар	-	Хангалттай сайн	Хангалттай	80.0
16	Хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн чанар	-	Хангалттай сайн	Хангалттай сайн	80.0
17	Хяналт шинжилгээ, үнэлгээний семинар, сургалтын арга хэмжээ, хурал зэргийн оролцогчдын тоо (хүйс болон харъяаллаар ангилсан)	0 гэж тооцно	300	2015 оны байдлаар 600 оролцогч хамрагдсан байсан.	100
<b>Дундаж</b>					<b>85.0</b>
<b>Ерөнхий дундаж үнэлгээ</b>					<b>62.8</b>

**6.3. Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл аж иллагааны гүйцэтгэлийн үнэлгээ:**

<b>Зорилт, арга хэмжээ</b>	<b>Үнэлгээ</b>
<b>Нэг. Малчдыг зах зээлтэй холбох</b>	
1.1. Мах, ноос, ноолуурын зах зээлийг хөгжүүлэх:	85.0%
1.2. Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийг хөгжүүлэх:	50.0%
1.3 Хүнсний ногоо, жимс, жимсгэний туршилтын үйлдвэрлэл:	75.0%
<b>Дундаж үнэлгээ</b>	<b>70.0%</b>
<b>Хоёр. Малын ашиг шим чанарыг сайжруулах</b>	
2.1. Малын эрүүл мэндийг сайжруулах: Малын өвчингүй эрүүл бүсийг бэхжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх замаар малын ашиг шим, эрүүл мэндийг сайжруулна.	100%
2.2. Малын үржил, сонгон үржүүлэг: Хонь, ямаа, сүүний болон махны чиглэлийн үхэрт хөрөнгө оруулах замаар малын чанар, малын үржлийн ажлын менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	100%
2.3.Малын тэжээл, тэжээллэг: Малын тэжээллэгийг сайжруулах замаар малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.	100%
<b>Дундаж үнэлгээ</b>	<b>100%</b>
<b>Гурав. Төслийн удирдлага</b>	
3.1. Төслийн хэрэгжилт, зохицуулалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор техникийн туслалцаа үзүүлэх сургалт зохион байгуулах;	95.0%
<b>Ерөнхий дундаж үнэлгээ</b>	<b>86.4%</b>

**ДОЛОО. ДҮГНЭЛТ**

1. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 2016 оны эцэс хүртэлх хугацаанд нийт төсвийн 71.7 хувийг зарцуулсан бөгөөд төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 62.8 %, төслийн үйл ажиллагааны гүйцэтгэл 86.4 % буюу “хангалттай” үнэлгээтэй байна.

2. Төсөл хэрэгжүүлэх нэгж 2016 онд үйл ажиллагаагаа эрчимжүүлэн ажиллаж оролцогч 5 аймгийн 15 суманд хэрэгжүүлж байгаа нэмүү өртгийн сүлжээний 12, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний 67, малын эрүүл мэндийн 67, малын үржлийн 41, малын тэжээл, тэжээллэгийн 18, нийт 205 дэд төслийг санхүүжүүлж, нийтдээ 4.6 сая ам.доллар буюу төслийн нийт зардлын 41.8 хувьтай тэнцэж хэмжээний төсөв зарцуулан ажилласан байна.

3. Төслийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнахдаа Даян дэлхийн хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал хөтөлбөрийн буцалтгүй тусламжийн TF014820 дугаартай гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээг бүрэн хамруулах, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хангах, өмнөх жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар хангалтгүй ажилласан байна.

**НАЙМ. ЗӨВЛӨМЖ**

- Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр удаашралтай, хангалтгүй биелэлттэй гарсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг бүрэн хангахад анхаарч ажиллах.
- Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, санхүүжүүлсэн төслийн үр дүн, үр нөлөөг илэрхийлэх баримт, тоон мэдээлэл, судалгааны үр дүнг тайланд тодорхой тусгаж ирүүлэх.